

EBC Санхүүгийн Групп “Шилдэг CFD Үйлчилгээ Үзүүлэгч” шагнал хүртлээ

Online Money Awards-аас CFD-ийн ил тод байдал, арилжаачдад чиглэсэн бүтээгдэхүүний хөгжүүлэлт зэрэгт EBC дэлхийд тэргүүлэгч байр суурийг бататгаж байна.

LONDON, UNITED KINGDOM, July 4, 2025 /EINPresswire.com/ -- EBC Санхүүгийн Групп 2025 оны Online Money Awards-аас “Шилдэг CFD үйлчилгээ үзүүлэгч” хэмээх нэр хүндтэй шагналыг хүртэж, уг салбарын нэр хүндтэй тавцангаас анхны хүлээн зөвшөөрлөө авлаа. Энэ шагнал тус группийн олон төрлийн хөрөнгө дээр суурилсан бүтээгдэхүүний өргөтгөл, арилжааны гүйцэтгэлийн технологийн сайжруулалт, тэр дундаа CFD зах зээлд чиглэсэн харилцагч төвтэй шинэчлэлүүдийг амжилттай нэвтрүүлж байгааг илтгэн харуулж байна.

Шагналтай зэрэгцэн EBC нь 100 гаруй АНУ-д бүртгэлтэй ETF-ийн CFD-г шинээр нэвтрүүлснээр арилжааны бүтээгдэхүүний сонголтоо өргөжүүлээд байна. Энэхүү шинэчлэл нь хэрэглэгчдэд хөшүүрэгтэй аргаар дэлхийн зах зээл дээрх сэдэвчилсэн болон салбарын чиг хандлагад суурилсан боломжуудыг санал болгож буй юм. Арилжаачид цэвэр эрчим хүч, АНУ-ын технологийн хувьцаа, ноогдол ашигтай хөрөнгүүд, тогтмол орлоготой үнэт цаас болон шинээр гарч ирж буй зах зээлүүд зэрэг сэдвүүдээр бодлого тодорхойлсон арилжаа хийх боломжтой болж байна.

“Энэ шагнал EBC өнөөгийн арилжаачдын хэрэгцээнд уян хатан байдал, ил тод байдал болон илүү ухаалаг, төрөлжсөн бүтээгдэхүүнүүдээр хэрхэн хариу үзүүлж байгаагийн илрэл юм. Бидний санал болгож буй ETF-ийн CFD нь эдгээрийг тэргүүлэх чиглэл болгосон бөгөөд харилцагчдад зардал багатай, шууд гүйцэтгэлтэй, зах зээлийн аль ч чиглэлд байр суурь эзлэх боломжтой арилжааг санал болгож байна. Энэ ялалт нь EBC-ийн үргэлж арилжаачдыг



EBC СанхүүгийнГрупп 2025 оны Online Money Awards-аас “Шилдэг CFD Үйлчилгээ Үзүүлэгч” шагналыг хүртлээ — дэлхийн CFD арилжааны салбарт уян хатан байдал, шинэлэг хандлага, өндөр гүйцэтгэл бүхий үйлчилгээ үзүүлж байгаагаараа үнэлэгдэв.

нэн тэргүүнд тавьж ажилладаг зарчмыг дахин баталж өглөө” хэмээн EBC Санхүүгийн Групп (UK) ХХК-ийн Гүйцэтгэх захирал Дэвид Барретт онцоллоо.

ETF-ийн CFD: Сэдэвчилсэн хандалт, стратегийн хяналт

EBC-ийн платформ дээр 100 гаруй ETF-ийн CFD шинээр нэмэгдсэн нь тус компанийн бүтээгдэхүүний цар хүрээг мэдэгдэхүйц өргөжүүлж буйг харуулж байна. Харилцагчид одоо NYSE болон NASDAQ дээр бүртгэлтэй, Vanguard, iShares (BlackRock) болон State Street Global Advisors-ийн гаргасан ETF-үүдээр арилжаа хийх боломжтой болсон. Эдгээр нь дараах чиглэлүүдийг хамарч байна:

Газарзүйн чиглэлээр: iShares MSCI Brazil ETF, Ази-Номхон далай бүс нутгийг хамарсан ETF-үүд

Салбарын чиглэлээр: АНУ-ын эрүүл мэнд, эрчим хүч, хэрэглээний бүтээгдэхүүн, технологийн салбар

Тогтмол орлоготой хөрөнгө оруулалт: өндөр өгөөжтэй болон хөрөнгө оруулалтын зэрэглэлийн бондын ETF-үүд

Мөн харилцагчид хувьцааны хэв маягт суурилсан индексүүд (жишээ нь Value, Growth, болон Dividend төвтэй сагс) дээр арилжаа хийх боломжтой болсон. Энэ нь хөрөнгийн портфолиог илүү нарийн төвөгтэй, зорилтот байдлаар бүрдүүлэхэд тусална.

Уламжлалт ETF хөрөнгө оруулалтаас ялгаатай нь EBC-ийн CFD бүтэц арилжаачдад сангийн удирдлагын төлбөргүйгээр зах зээлд нэвтрэх боломж олгож, аль ч чиглэлд (лонг буюу өсөлт, шорт буюу уналт) арилжаа хийх уян хатан нөхцөлийг бүрдүүлдэг.

Өндөр хөшүүрэг, ихэнх арилжаанд шимтгэлгүй байх зэрэг давуу талтайгаар, энэ шинэ ETF CFD бүтээгдэхүүний цуврал нь сэдэвчилсэн төрөлжилт ба стратегийн боломжийг зэрэг эрэлхийлдэг идэвхтэй арилжаачдад оновчтой шийдэл болж байна.

Платформын чадамж болон арилжааны гүйцэтгэлийг сайжрууллаа

EBC Financial Group нь 2025 онд Online Money Awards-аас шагнал хүртсэн нь тэдний платформд хийсэн олон шинэчлэлийн үр дүн юм. Үүнд: олон хэлний дэмжлэгийн өргөтгөл, ухаалаг ханш дамжуулалтын систем (smart liquidity routing), арилжааны гүйцэтгэлийг 20 миллисекунд хүрэхүйц хурдтай болгох техник сайжруулалтууд багтаж байна.

Мөн EBC-ийн дотоод бүтээсэн хэрэгслүүд болох Trading Black Box болон Private Room арилжаачдад ханшийн хяналт, гүйцэтгэлийг илүү нарийн хянах боломжийг олгож, олон улсын зах зээлд найдвартай, өндөр гүйцэтгэлтэй платформ хүргэх зорилгыг дэмждэг.

Online Money Awards Holiston Media-гийн зохион байгуулдаг нэр хүндтэй шагнал бөгөөд санхүүгийн үйлчилгээ болон финтек салбарын шилдгүүдийг тодруулдаг. Ялагчдыг редакцийн дүгнэлт болон хөрөнгө оруулагчдын санал хүсэлтийн үндсэн дээр тодруулдаг.

Энэхүү шинэ хүлээн зөвшөөрөлт нь EBC-ийн 2025 онд хүртсэн олон шагналуудын цуваад нэмэгдэж буй бөгөөд үүнд World Finance Forex Awards 2025-аас авсан:

- “Хамгийн итгэмжлэгдсэн брокер”,

- “Шилдэг арилжааны платформ” зэрэг хоёр дахин ялалт ч багтана.

Эдгээр амжилт нь EBC-ийн олон хөрөнгийн ангилал, харилцагчийн төрөл бүрийн сегментүүдэд чиглэсэн дэлхий дахины өсөлтийг улам бататгаж байна.

Анхааруулга: Энэхүү нийтлэл EBC Санхүүгийн Групп болон түүний охин компаниудын дүгнэлт, ажиглалтад тулгуурласан болно. Санхүүгийн зөвлөгөө биш юм. Түүхий эд, валютын арилжаа (FX) анхны хөрөнгө оруулалтаас давсан алдагдал хүлээх өндөр эрсдэлтэй байдаг тул, арилжаа хийхээсээ өмнө мэргэжлийн зөвлөхтэй зөвлөлдөхийг зөвлөж байна. EBC болон түүний салбарууд энэ мэдээлэлд үндэслэж гарсан аливаа хохиролд хариуцлага хүлээхгүй.

EBC Financial Group-ийн шагнал хүртсэн үйлчилгээний талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл манай вэб сайтаар зочлоорой: www.ebc.com

###

EBC Санхүүгийн Группийн Тухай

Лондон хотын санхүүгийн төвд үүсгэн байгуулагдсан EBC Санхүүгийн Групп хөрөнгө удирдлага, брокерийн үйлчилгээний чиглэлээр олон улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг. Лондон, Сидней, Хонконг, Сингапур, Кайманы арлууд, Бангкок, Лимассол зэрэг дэлхийн томоохон санхүүгийн төвүүдэд салбартай тус компани хувь хүн болон байгууллагуудад валют, түүхий эд, хувьцаа, индекс зэрэг олон төрлийн санхүүгийн зах зээлд шууд нэвтрэх боломжийг олгодог.

Компанийн бүс нутгийн салбарууд харьяа улсынхаа зохицуулах байгууллагаар зохицуулагддаг бөгөөд ёс зүй, ил тод байдлыг гол зарчим болгож ажилладаг. EBC Санхүүгийн Групп (UK) Limited нь Их Британийн Санхүүгийн Үйлчилгээний Хорооны (FCA) харьяанд, EBC Санхүүгийн Групп (Cayman) Limited нь Кайманы Арлуудын Санхүүгийн Зохицуулах Газраар (CIMA), харин Австралийн салбарууд нь Австралийн Үнэт Цаас ба Хөрөнгө Оруулалтын Комиссын (ASIC), EBC Financial (MU) Ltd Маврикийн Санхүүгийн Үйлчилгээний Хорооны (FSC) зохицуулалтад тус тус хамаардаг.

40 гаруй жилийн туршлага бүхий санхүүгийн мэргэжилтнүүдээс бүрдсэн EBC-ийн баг Плазагийн Гэрээ, 2015 оны Швейцар франкийн хямрал, COVID-19 цар тахлын үеийн зах зээлийн савлагаа зэрэг дэлхийн томоохон эдийн засгийн мөчлөгүүдийг даван туулж ирсэн туршлагатай. Компанийн соёл нь шударга байдал, харилцан хүндлэл, хөрөнгө хамгаалалтыг нэн тэргүүнд тавьж, хөрөнгө оруулагч бүрийн харилцааг онцгой ач холбогдолтойгоор хүлээн авч, хүндэтгэлтэй ханддаг зарчимд тулгуурладаг.

EBC Санхүүгийн Групп алдарт FC Barcelona клубын Албан ёсны Гадаад Валютын Түнш байгууллага бөгөөд Ази, Латин Америк, Ойрхи Дорнод, Африк болон Номхон далайн бүс нутгуудад тусгай чиглэлийн санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг. НҮБ-ын Сан болон дэлхийн хамгийн том оролцоонд суурилсан кампанит ажил болох “United to Beat Malaria” хөтөлбөрийн түншлэлийн хүрээнд дэлхийн эрүүл мэндийн санаачлагуудад хувь нэмэр оруулж байна.

Мөн EBC Оксфордын Их Сургуулийн Эдийн Засгийн Тэнхимийн хэрэгжүүлдэг “Эдийн засагчид юу хийдэг вэ?” олон нийтэд зориулсан боловсролын цувралыг дэмжин оролцож, эдийн засгийн ойлголтыг олон нийтэд энгийн, хүртээмжтэй байдлаар хүргэж, нийгмийн тулгамдсан асуудлуудын талаарх ойлголт, хэлэлцүүлгийг гүнзгийрүүлэхэд хувь нэмрээ оруулж байна. <https://www.ebc.com/>

Michelle Siow
EBC Financial Group
+60 163376040
michelle.siow@ebc.com

Visit us on social media:

[LinkedIn](#)
[Instagram](#)
[Facebook](#)
[YouTube](#)
[X](#)
[Other](#)

This press release can be viewed online at: <https://www.einpresswire.com/article/828288902>

EIN Presswire's priority is source transparency. We do not allow opaque clients, and our editors try to be careful about weeding out false and misleading content. As a user, if you see something we have missed, please do bring it to our attention. Your help is welcome. EIN Presswire, Everyone's Internet News Presswire™, tries to define some of the boundaries that are reasonable in today's world. Please see our Editorial Guidelines for more information.

© 1995-2025 Newsmatics Inc. All Right Reserved.